ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 25 ХУВИЙГ УРСГАЛ ЗАРДЛЫН ШИНЖТЭЙ ЗҮЙЛСЭД ЗАРЦУУЛСАН НЬ САНГИЙН ХӨРӨНГӨӨС ИРГЭДИЙН ХҮРТЭХ ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.**

## АУДИТЫН КОД: ХӨА-2025/31-21-ШТА-ГА

**Хөвсгөл аймаг**
**2025 он**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Аудитор: Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

**Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.** https://audit.mn/?page_id=579

## АГУУЛГА

**Тайланг бэлтгэсэн:**

**Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар**

*Тэргүүлэх аудитор*
*А.Эрдэнэбаатар*
*Аудитын менежер*
*Б.Тэгшдэлгэр*
*Ахлах аудитор*
*Г.Ичинхорлоо*
*Аудитор*
*Л.Мөнх-Оргил*
*Л.Мандахнаран*
*Х.Энхтуяа*

*Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл гарвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу.*

***ХАЯГ:*** *Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын "А" корпус 3 давхар*

**Цахим хаяг:**
audit.mn/?page_id=579

**2025 оны 08 дугаар сар**

Товчилсон үгийн тайлбар

Аудитын тайлан баталгаажуулах тушаал, хавсралт

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

**Бүлэг 1. Орон нутаг нөөц боломжоо бүрэн дайчилж ажиллаагүйгээс 1,306.1 сая төгрөгөөр орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.**

*1.1 Орон нутаг нөөц боломжоо бүрэн дайчилж ажиллаагүйгээс 1,306.1 сая төгрөгөөр орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.*

*1.2. Шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж байна.*

**Бүлэг 2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 25 хувийг урсгал зардлын шинжтэй зүйлсэд зарцуулсан нь сангийн хөрөнгөөс иргэдийн хүртэх үр өгөөжийг бууруулж байна.**

*2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах хяналт хангалтгүйгээс шалтгаалан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжээгүй байхад ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг олгосон байна.*

*2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 25 хувийг урсгал зардлын шинжтэй зүйлсэд зарцуулсан нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс иргэдийн хүртэх бодит үр өгөөжийг бууруулж байна.*

*2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,519.2 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.*

**Бүлэг 3. Захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ чанаргүй болох, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг үүсгэж байна.**

*3.1 Захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ чанаргүй болох, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг үүсгэж байна.*

*3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 818.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.*

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн нэгтгэл

**Товчилсон үгийн тайлбар**

| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
|---|---|
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ХөТАГ | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ИНХ | Иргэдийн Нийтийн Хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| БОНХОБТХ | Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс |
| СТСХ | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| ХШҮДАХ | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| СХАА | Санхүүгийн хяналт, аудитын алба |
| ТБОНӨБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| АМАТЗШ | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үндэслэл |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |
| ЦДАШ | Цахилгаан дамжуулах агаарын шугам |
| НТШ | Нээлттэй тендер шалгаруулалт |
| ХХК | Хариуцлагатай хувьцаат компани |
| ШГБ | Шууд гэрээ байгуулах |
| ШХА | Шууд худалдан авалт |
| ОНО | Олон нийтийн оролцоотой |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 01 өдөр Дугаар А/28 Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Их Хурлын Тэсвийн Байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4, 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Мөрөн сумын Засаг дарга, Баянзүрх сумын Засаг дарга, Бүрэнтогтох сумын Засаг дарга, Тосонцэнгэл сумын Засаг дарга, Түнэл сумын Засаг дарга, Ханх сумын Засаг дарга, Цэцэрлэг сумын Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн А/28 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

| № | Төлбөрийн акт, албан шаардлагын дугаар | Утга | Дүн төгрөгөөр |
|---|---|---|---|
| 1 | 123/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Төлбөр барагдуулах тухай | 1,273,300.0 |
| 2 | 124/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Төлбөр барагдуулах тухай | 662,837.0 |
| 3 | 125/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Төлбөр барагдуулах тухай | 5,000,000.0 |
| 4 | 91/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 3,477,826.0 |
| 5 | 92/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 301,600,000.0 |
| 6 | 93/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 676,000,000.0 |
| 7 | 94/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 210,763,400.0 |
| 8 | 95/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 8,424,300,000.0 |
| 9 | 96/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | - |
| 10 | 97/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 177,100,000.0 |
| 11 | 98/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 386,700,000.0 |
| 12 | 99/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 239,000,000.0 |
| 13 | 100/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 365,000,000.0 |
| 14 | 101/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 357,200,000.0 |
| 15 | 102/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 208,700,000.0 |
| 16 | 103/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 78,300,000.0 |
| 17 | 104/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | - |
| 18 | 105/А2270648/ХӨА-2025/31-21-ШТА-ГА | Зөрчил арилгах тухай | 35,000,000.0 |
| **Нийт** | | | **11,470,077,363.0** |

--oo0oo-

## Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108, “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны А/107 дугаар тушаал, Монгол улсын Ерөнхий аудитортай байгуулсан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” –д гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

**Аудитын зорилт:**

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх

**Аудитын хамарсан хүрээ:**

Аудитаар 2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба, Санхүүгийн хяналт, аудитын алба, Барилга захиалагчийн хяналтын төв, Мөрөн, Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Арбулаг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын тамгын газар, баг хорооны дарга, иргэдийн нийтийн хурал болон бусад холбогдох төрийн байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг Хөвсгөл аймгийн хэмжээн дэх Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны эх үүсвэр бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналт болон холбогдох бусад баримтад тулгуурлан гүйцэтгэв.

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 ”Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт хийсэн баримт материал, ажлын тайлан, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв,

магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, шийдвэрийг боловсруулав.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал";
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам";
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам";
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам";
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

**Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:**

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Ичинхорлоо, аудитор Л.Мөнх-Оргил, Л.Мандахнаран, Х.Энхтуяа нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

**Аудитад үүссэн хязгаарлалт:** Аудитыг гүйцэтгэсэн хугацаа нь ээлжийн амралтын хугацаатай давхацсанаас холбогдох зарим албан хаагчид тайлбар тодруулгыг хугацаанд өгч чадахгүй байх зэрэг нөхцөл байдлыг үүсгэсэн.

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Төсвийн тухай хуульд "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ" гэж заасан байна.

Орон нутгийн удирдлага, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-аар зохицуулж байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг Хөвсгөл аймагт 15,990.4 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулиар 748.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн

орлогын шилжүүлгийг 16,739.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 16,065.8 сая төгрөгийг олгожээ.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн эхний үлдэгдэл 4,353.4 сая төгрөг, сангийн эх үүсвэрт нийт 18,820.6 сая төгрөгийг төлөвлөснөөс 17,963.2 сая төгрөгийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 17,806.9 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 4,509.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт №1. ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл* /сая.төгрөг/

| № | Аймаг, нийслэл нэр | ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл | Нийт эх үүсвэр | | Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн | ОНХС-ийн харилцах дансны эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төл | Гүйц | | |
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6=2+4-5 |
| 1 | Алаг-Эрдэнэ | 63.6 | 649.3 | 598.5 | 586.8 | 75.3 |
| 2 | Арбулаг | 2.7 | 355.3 | 341.0 | 275.1 | 68.5 |
| 3 | Баянзүрх | 42.7 | 447.4 | 351.9 | 343.2 | 51.3 |
| 4 | Бүрэнтогтох | 106.1 | 954.1 | 954.1 | 838.5 | 221.6 |
| 5 | Галт | 20.0 | 436.0 | 409.1 | 393.1 | 36.0 |
| 6 | Жаргалант | 61.2 | 279.9 | 279.9 | 263.1 | 78.0 |
| 7 | Их-Уул | 51.5 | 273.9 | 266.0 | 314.7 | 2.8 |
| 8 | Мөрөн | 380.6 | 1,015.9 | 1,023.5 | 1,163.3 | 240.8 |
| 9 | Рашаант | 9.1 | 242.9 | 248.9 | 211.0 | 47.0 |
| 10 | Рэнчинлхүмбэ | 436.6 | 444.7 | 444.7 | 448.2 | 433.1 |
| 11 | Тариалан | 83.6 | 428.9 | 424.6 | 453.4 | 54.8 |
| 12 | Тосонцэнгэл | 83.4 | 361.6 | 330.2 | 354.8 | 58.8 |
| 13 | Төмөрбулаг | 70.1 | 374.3 | 317.3 | 224.2 | 163.2 |
| 14 | Түнэл | 4.5 | 483.1 | 485.1 | 393.2 | 96.4 |
| 15 | Улаан-Уул | 49.8 | 436.4 | 418.6 | 290.2 | 178.2 |
| 16 | Ханх | 160.7 | 269.6 | 237.0 | 157.0 | 240.6 |
| 17 | Хатгал | 89.9 | 126.3 | 126.3 | 197.2 | 19.0 |
| 18 | Цагааннуур | 122.5 | 319.1 | 319.1 | 123.7 | 317.8 |
| 19 | Цагаан-Уул | 342.9 | 956.8 | 956.8 | 1,084.9 | 214.8 |
| 20 | Цагаан-Үүр | 216.4 | 570.0 | 570.0 | 528.1 | 258.3 |
| 21 | Цэцэрлэг | 171.5 | 2,048.3 | 1,995.6 | 1,303.3 | 863.8 |
| 22 | Чандмань өндөр | 58.8 | 288.6 | 282.1 | 225.6 | 115.3 |
| 23 | Шинэ-Идэр | 13.5 | 221.2 | 212.7 | 201.9 | 24.3 |
| 24 | Эрдэнэбулган | 145.2 | 298.5 | 298.5 | 340.8 | 102.8 |
| | **Сумдын дүн** | **2,786.7** | **12,281.8** | **11,891.5** | **10,715.6** | **3,962.6** |
| 25 | Аймаг | 1,566.7 | 6,538.8 | 6,071.7 | 7,091.3 | 547.1 |
| | **Нийт дүн** | **4,353.4** | **18,820.6** | **17,963.2** | **17,806.9** | **4,509.7** |

Хөвсгөл аймагт 2024 онд нийт 696 төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймаг, сумдын ИТХ-аас баталсан байна.

Өмнөх онд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар 26.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 7,838.6 сая төгрөгийн 10 албан шаардлага, 2,940.2 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсний шийдвэрийн хэрэгжилтийг үнэлж үзэхэд хэрэгжилт дунджаар 75.0 хувьтай байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл, оролцоог үнэлэх зорилгоор Хөвсгөл аймгийн 1590 иргэнээс санал асуулга авч нэгтгэн дүгнэв.

# БҮЛЭГ 1: Орон нутаг нөөц боломжоо бүрэн дайчилж ажиллаагүйгээс 1,306.1 сая төгрөгөөр орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

## 1.1 Орон нутаг нөөц боломжоо бүрэн дайчилж ажиллаагүйгээс 1,306.1 сая төгрөгөөр орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

***1.1.1*** Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн санд Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасан эх үүсвэрээс 2024 онд нийт 22,249.6 сая төгрөгийг бүрдүүлсэн байна. ***Хүснэгтээр харуулбал:***

ОНХС-ийн эх үүсвэр

*Хүснэгт №2.* */сая төгрөгөөр/*

| Эх үүсвэр | Гүйцэтгэл | Хувийн жин |
|---|---|---|
| **2024 оны ОНХНС болон улсын төсөв** | **16,065.8** | **73%** |
| *ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг* | *15,066.3* | *68%* |
| *Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл* | *62.5* | *1%* |
| *"Тогтвортой амьжиргаа-3" төсөл урамшуулал* | *937.0* | *4%* |
| **2024 оны Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр** | **6,183.9** | **27%** |
| *Өмнөх оны дансны үлдэгдэл* | *4,286.5* | *19%* |
| *Зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэр* | *547.0* | *2%* |
| *Малын тоо толгойн албан татвар* | *1,350.3* | *6%* |
| **НИЙТ** | **22,249.6** | **100%** |

ОНХС-ийн эх үүсвэрийн 73 хувийг ОНХНС болон улсын төсвөөс, 27 хувийг орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

**ОНХНС болон улсын төсвөөс Хөвсгөл аймаг хуваарилсан орлогыг харуулбал:**

*Хүснэгт №3* */сая төгрөгөөр/*

| Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар | “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар | Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан | Сангийн яамнаас гүйцэтгэлээр олгосон санхүүжилт |
|---|---|---|---|
| 15,990.4 | 16,739.1 | 15,990.4 | 16,065.8 |

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг Хөвсгөл аймагт 15,990.4 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар 748.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч Хөвсгөл аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн төсвийн тодотголын төслийг боловсруулахдаа эх үүсвэрийг нэмж төлөвлөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4[1] гэсэн заалттай нийцэхгүй байна.

Сангийн яамнаас улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгийг гүйцэтгэлээр 16,065.8 сая төгрөгийг олгожээ.

***1.1.2***. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь заалтууд, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу тооцсон байна.

[1] *өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах*

*Хүснэгт №4* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | Нийт |
|---|---|---|---|
| Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл | | 62.5 | 62.5 |
| *"Тогтвортой амьжиргаа-3" төсөл урамшуулал* | | 937.0 | 937.0 |
| ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг /итгэлцүүрээр тооцсон дүн/ | 5,996.4 | 8,994.5 | 14,990.9 |
| Итгэлцүүрийн хувь | 40% | 60% | 100 |
| **НИЙТ ДҮН** | **5,996.4** | **9,994.1** | **15,990.5** |

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр болон өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээний дагуу Тогтвортой амьжиргаа-3 төслөөс олгодог урамшууллыг сумдад шууд шилжүүлж, ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг хүн амын тоо, нутаг дэвсгэрийн болон ашигт малтмалын ашиглалтын талбайн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн итгэлцүүрээр тооцож хуваарилсан байна. /Итгэлцүүрээр сумдад хуваарилсан дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт №1-ээс харна уу/

***1.1.3*** Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн “Аймгийн 2024 төсөвт тодотгол хийх тухай” 07 дугаар тогтоол, Сангийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 152 дугаар тушаалд үндэслэн Аймгийн засаг дарга аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хуваарийг баталсан байна. ОНХНС-аас ирсэн санхүүжилтийн хуваарилалтыг улирлаар харуулбал:

*Хүснэгт №5* */сая төгрөгөөр/*

| Санхүүжилт | Санхүүжилтийн хуваарь | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| 1-р улирал | 1,448.0 | 1,448.0 | 0.0 |
| 2-р улирал | 5,758.2 | 5,758.2 | 0.0 |
| 3-р улирал | 4,425.2 | 4,425.2 | 0.0 |
| 4-р улирал | 4,359.0 | 4,434.4 | 75.4 |
| **НИЙТ** | **15,990.5** | **16,065.8** | **75.4** |

Сангийн яамнаас 2024 оны 4-р улирлын санхүүжилтийг 75.4 сая төгрөгөөр илүү олгосныг аймгийн ОНХС-д хуваарилсан байна.

***1.1.4.*** Аймаг, сумын ИТХ-аас Төсвийн тухай хуулийн 60.2-д заасны дагуу ОНХС-ийн эх үүсвэрийг 2,830.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

*Хүснэгт №6* */сая төгрөгөөр/*

| Орлогын нэр төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| *Зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэр* | 1,211.1 | 547.0 | 664.1 |
| *Малын тоо толгойн албан татвар* | 1,619.0 | 1,350.3 | 268.7 |
| **НИЙТ** | 2,830.1 | 1,897.3 | 932.8 |

Орон нутгийн өөрийн орлогоос ОНХС-ийн эх үүсвэр болгохоор 2,830.1 сая төгрөгийг төлөвлөсөн ба 1,897.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангасан байна. /ОНХС-ийн эх үүсвэрийн дэлгэрэнгүй судалгааг хавсралт №2-ээс харна уу/

*<u>Зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэрийн орлогын тухайд:</u>*

Орон нутгийн давсан орлогын хэсгээс ОНХС-ийн эх үүсвэр болгохоор төлөвлөсөн 1,211.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Үүнд:

*Хүснэгт №7* */сая төгрөгөөр/*

| ОНХС | Төлөв | Гүйц | Зөрүү |
|---|---|---|---|
| *Аймгийн ОНХС* | 542.4 | 0.0 | 542.4 |
| *Сумдын ОНХС /15 сум/* | 668.7 | 547.0 | 121.7 |
| **НИЙТ** | **1,211.1** | **547.0** | **664.1** |

Аймгийн ОНХС-д орон нутгийн орлогоос төлөвлөсөн эх үүсвэрийг 542.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3[2] гэсэн заалттай нийцэхгүй байна.

[2] *ОНХС-ийн орлогын шилжүүлгийг тус санг бүрдүүлдэг эх үүсвэрүүдийн орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх*

*Малын тоо толгойн албан татварын орлогын тухайд:*

Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгоны хэмжээнд 2024 онд нийт 1,619.0 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварын орлогыг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,350.3 сая төгрөгийг ОНХС-ийн эх үүсвэр болгосон байна. Малын тоо толгойн албан татварын орлогыг 8 сум тасалсан байна. Үүнд:

*Хүснэгт №8* *\/сая төгрөгөөр/*

| № | Сумын нэр | Төлөв | Гүйц | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Алаг-Эрдэнэ | 100.0 | 66.1 | 33.9 |
| 2 | Баянзүрх | 94.9 | 74.3 | 20.5 |
| 3 | Бүрэнтогтох | 156.6 | 106.5 | 50.1 |
| 4 | Галт | 90.3 | 62.8 | 27.5 |
| 5 | Тариалан | 102.8 | 93.4 | 9.3 |
| 6 | Төмөрбулаг | 157.2 | 100.3 | 57.0 |
| 7 | Улаан-Уул | 40.0 | 22.3 | 17.7 |
| 8 | Цэцэрлэг | 73.6 | 20.9 | 52.7 |
| | **НИЙТ** | **815.3** | **546.6** | **268.7** |

Малын тоо толгойн албан татварын төлөвлөсөн орлогыг хүснэгтэд дурдсан сумд 268.7 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1[3] дэх заалттай нийцэхгүй байна. Малын тоо толгойн албан татвараас бүрдүүлсэн орлогыг Баянзүрх сум 15.0 сая төгрөгөөр, Галт сум 0.3 сая төгрөгөөр нийт 15.3 сая төгрөгөөр ОНХС-ийн эх үүсвэрт бүрэн төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8[4] дахь заалтыг зөрчсөн байна.

Өмнө жилийн буюу 2023 оны малын тоо толгойн албан татварын давсан орлого 29.1 сая төгрөгийг дараах сумд 2024 оны ОНХС-ийн эх үүсвэр болгож батлаагүй байна. Үүнд:

- Жаргалант сум 5.3 сая төгрөг
- Түнэл сум 13.1 сая төгрөг
- Цагаан-Уул сум 8.3 сая төгрөг
- Чандмань-Өндөр сум 0.7 сая төгрөг
- Хатгал тосгон 0.6 сая төгрөг
- Эрдэнэбулган сум 1.1 сая төгрөг

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.2.8 дахь заалт болон Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.8[5] дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн сумдын малын тоо толгойн албан татвар төлөвлөсөн байдлыг 2023 оны жилийн эцсийн малын тоо толгойн тоо болон сумдын ИТХ-аас тогтоосон татварын хувь хэмжээнд үндэслэн тооцож үзэхэд зарим сумд малын тоо толгойн албан татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж чадаагүйгээс **528.4** сая төгрөгөөр ОНХС-ийн эх үүсвэр нэмэгдүүлэх боломжийг алдсан байна./Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт №3-оос харна уу/

*Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Хөвсгөл аймагт олгохоор баталсан дүнг 748.6 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцоолоогүйгээс 528.4 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн, өмнөх жилийн малын тоо толгойн албан татварын давсан орлого 29.1 сая төгрөгийг тайлант онд эх үүсвэр болгоогүй, нийт 1,306.1 сая төгрөгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан нь орон нутаг нөөц боломжоо бүрэн дайчилж ажиллахгүй байгааг харуулж байна.*

[3] хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

[4] малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

[5] ОНХС-ийн болон сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ

### 1.2 *Шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөвлөгчдийн саналаар баталж байна.*

***1.2.1.*** Аймаг, сумын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тухайн хөрөнгө оруулалтын ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.2, 63.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5, 6, 7 дугаар зүйлд заасан.

Аймаг, сумын ОНХС-г төлөвлөхдөө тухайн шатны Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Баг, хороодын иргэд нийтийн хурлаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг авч, хэлэлцүүлсэн
- Баг, хорооны иргэд нийтийн хурлаас баталж ирүүлсэн жагсаалтыг сумын хэмжээнд нэгтгэж эрэмбэлсэн.
- Нэгдсэн жагсаалтыг боловсруулахдаа сумын хөгжлийн төлөвлөгөө, тухайн сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээ, сумын тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан эсэхийг харгалзаж үзсэн байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд аймаг, сумын ОНХС-г төлөвлөхдөө нийт 42750 иргэнээс нийт 1149 төсөл арга хэмжээний саналыг авсан байна. ОНХС-д иргэдийн санал өгсөн хэлбэрийг харуулбал:

*График №1*




Нийт санал өгсөн иргэдийн 82.4 хувь буюу 35247 иргэнээс цаасаар авсан бол 6.4 хувь буюу 2724 иргэнээс цахимаар, 11.2 хувь буюу 4779 саналыг бүлгийн ярилцлагын хэлбэрээр авсан байна. ОНХС-ийн санал асуулгад Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн насны иргэдийн 43.7 хувийг хамруулсан байна.

Аудитаар ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан төсөл арга хэмжээнд иргэдийн санал авсан эсэхийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. /Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт №4-ээс харна уу/ Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 4,884.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээ,
- Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 676.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээ,
- Бүрэнтогтох сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 421.4 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ,
- Цэцэрлэг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 463.4 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ нь иргэдийн саналаар дэмжигдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6[6], Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2[7] дахь заалттай тус тус нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

[6] орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.
[7] ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх оролцооны талаарх санал асуулгыг гүүгл форум (google forum) ашиглан санал авч нэгтгэхэд дараах байдалтай байна.




ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд саналаа өгсөн үү ? гэсэн асуулгад нийт оролцогчдын 73.4 хувь нь “Тийм” гэж хариулсан бол 26.6 хувь нь “Үгүй” гэж хариулсан байна.




Төсөл арга хэмжээний саналыг ямар хэлбэрээр өгсөн бэ? Гэсэн асуултад 47.0 хувь нь “Багийн иргэдийн нийтийн хурал дээр цаасаар”, 20.8 хувь нь “Гар утасны аппликейшнээр” 5.7 хувь нь “ОНХС-ийн удирдлага мэдээллийн системээр” 2.0 хувь нь “Бүлгийн ярилцлагаар” гэсэн бол 24.5 хувь “Санал өгөөгүй” гэж хариулсан байна.

***1.2.2*** Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” болон аймгийн ИТХ-ын Хуралдааны 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтуудтай нийцсэн байна.

***1.2.3*** Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл, арга хэмжээг ИТХ-д өргөн барьж, батлуулахдаа тухайн шатны Засаг дарга төсөвлөлтийн шаардлагыг хангуулж техник эдийн засгийн үндэслэл зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн байх үүрэгтэй.

Аудитаар аймаг, сумдын ОНХС хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангуулж төлөвлөсөн эсэхийг хянахад дараах байдалтай байна. Үүнд:

- Аудитад хамрагдсан аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 7,320.7 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээнүүдийн ТЭЗҮ, зураг, төсөв нь 2024 оны төсөв баталснаас хойш хийгдсэн байна. /Дэлгэрэнгүй жагсаалтыг тайлангийн хавсралт №4-р харуулав/
- Зураг, төсөв, ТЭЗҮ хийгдээгүй төсөл арга хэмжээг баталснаас худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулдаггүй,
- Зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэл зөрүүтэй төсөв хүрдэггүй, зураг төсвийн хооронд зөрүүтэй байдал үүсдэг зэрэг эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4[8], Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “*Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам*”-ын 4.3.3[9]-т заасантай нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Бүрэнтогтох сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай” төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл хийгдсэн боловч санхүүжилтээ аваагүй байхад 2024 оны төсөв батлахдаа он дамжин

---

[8] *Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.*

[9] *ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;*

хэрэгжих шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж батлахгүйгээр 2024 онд санхүүжилтийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.1[10], Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.6[11] дахь заалттай тус тус нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

***1.2.4*** Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 696 төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “*Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам*”-ын 4.2-т заасан чиг үүрэгтэй нийцэж байгаа эсэхийг хянахад дараах байдалтай байна.

Аймгийн ОНХС-ын тухайд:

*График №2*




Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 47 хувийг дэд бүтэц, зам гүүр, 23 хувийг орчны тохижилт ногоон байгууламжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-т автомашин худалдан авах – 80.0 сая төгрөг
- Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах – 90.0 сая төгрөг

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6.2[12] дахь заалттай нийцэхгүй байна.

[10] шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ
[11] ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах
[12] Энэхүү журамд заасан болон Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүрэгт хамаарах;

Сумын ОНХС-ын тухайд:

*График №3*




Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 40 хувийг дэд бүтэц, зам гүүр, 13 хувийг орчны тохижилт, ногоон байгууламж, 20 хувийг иргэдийн эрүүл мэнд боловсрол, 14 хувийг малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Үүнээс малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээг чиг үүргээр нь задалж харуулбал:

*График №4*




Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 32 хувийг өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, 20 хувийг малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Ханх сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Баяр наадмын зардал /эв модны наадам/” төсөл арга хэмжээнд 10.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ын үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7.2[13], Монгол улсын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай (наадмын санхүүжилт)” -ийн 1 дүгээр заалттай[14] тус тус нийцэхгүй байна.

[13] Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал;

[14] Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн батлагсугай./

Сумын төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймгийн ОНХС-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн шатанд ирүүлсэн санал болон хэрэгжилтийг харьцуулан үзэхэд сум өөрийн төсвөөр хэрэгжүүлж болох төсөл арга хэмжээг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна. Сум өөрийн төсвөөр хэрэгжүүлж болох төсөл арга хэмжээг түүвэрлэн хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №9* *\/сая төгрөгөөр/*

| № | ТАХ-ний нэр | Төсөвт өртөг |
|---|---|---|
| 1 | Ахмад настны чийрэгжүүлэлтийн гадна талбайн тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум, 7-р баг/ | 30.0 |
| 2 | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн дэргэдэх хуучин уурын зуухны байрын буулгалт /Мөрөн сум/ | 19.0 |
| 3 | Эргийн 72 дугаар байрны дэргэдэх уурын зуухны чулуун барилгын буулгалт /Мөрөн сум/ | 19.0 |
| 4 | Эргийн 72 дугаар байрны дэргэдэх уурын зуухны өргөтгөлийн барилгын буулгалт /Мөрөн сум/ | 19.0 |
| 5 | Гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Мөрөн сум, Геологийн байр/ | 20.0 |
| 6 | Соёлын төвийн сандал /Төмөрбулаг сум | 10.0 |
| 7 | Худаг гаргах /Тариалан сум, ар тархи баг хуурай хөндий/ | 30.0 |
| 8 | Хүүхдийн цэцэрлэгийн тохижилт /Баянзүрх сум/ | 20.0 |
| 9 | Эмт багийн төвийн засвар, тохижилт /Баянзүрх сум/ | 20.0 |
| 10 | Дотуур байрны засвар /Бүрэнтогтох сум/ | 10.0 |
| 11 | Цэвэр усны машины сав худалдан авах /Цагаан-Уул сум/ | 19.7 |
| | **Нийт дүн** | **216.7** |

Дээрх төсөл арга хэмжээнүүд нь ИТХ-ын төлөөлөгчид хурлын хуралдаанд шууд санал оруулж баталдагтай холбоотой байна.

*ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлт болон журамд заасан чиг үүрэгтэй нийцүүлэн төлөвлөсөн боловч шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж байгаа нь төлөвлөлтийн шаардлага хангахгүй байгааг харуулж байна.*

## БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 25 ХУВИЙГ УРСГАЛ ЗАРДЛЫН ШИНЖТЭЙ ЗҮЙЛСЭД ЗАРЦУУЛСАН НЬ САНГИЙН ХӨРӨНГӨӨС ИРГЭДИЙН ХҮРТЭХ ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

### 2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах хяналт хангалтгүйгээс шалтгаалан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжээгүй байхад ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг олгосон байна.

***2.1.1***. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих 8,989.2 сая төгрөгийн 56 төсөл арга хэмжээ, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 12,233.5 сая төгрөгийн 525 төсөл арга хэмжээ нийт 21,222.7 сая төгрөгийн 581 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэлбэрийг авч үзвэл:

*Хүснэгт №10* *\/сая төгрөгөөр/*

| ХАА зохион байгуулсан хэлбэр | Аймгийн ОНХС | | Сумдын ОНХС | | НИЙТ | | Хувийн жин |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг | |
| Нээлттэй тендер шалгаруулалт | 20 | 6,796.9 | 27 | 3,956.2 | 47 | 10,753.1 | 8% |
| Харьцуулалтын арга | 24 | 1,712.0 | 88 | 3,911.5 | 112 | 5,623.5 | 19% |
| Олон нийтийн оролцоотой | | | 21 | 306.0 | 21 | 306.0 | 4% |
| Шууд гэрээ байгуулах | 12 | 480.3 | 389 | 4,059.9 | 401 | 4,540.2 | 69% |
| **НИЙТ** | **56** | **8,989.2** | **525** | **12,233.6** | **581** | **21,222.8** | 100% |

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нийт төлөвлөсөн төсөл арга хэмжээний 69 хувийг шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байгаагаас харахад төсөвт өртгийг хэт жижиглэж, урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаас зайлсхийсэн байж болохуйц харагдаж байна.

Аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хатгал тосгоны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 39.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хуучин халуун ус засварлах, ашиглалтад оруулах” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар 5 удаа зарласан хэдий ч тендерт нэг ч оролцогч оролцоогүйн улмаас шууд худалдан авалт хийсэн,
2. Эрдэнэбулган сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 38.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зам арчилгаа” төсөл арга хэмжээг шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.12[15] Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-тай нийцэхгүй байна.

3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн "Эхчүүдийн амрах байр барих ажлын төсөв /засвар шинэчлэлт/" төсөл арга хэмжээний гэрээг дүгнээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам*"-ын 4.8.29[16] гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчлийн хэмжээ нь материаллаг бус байгаа тул аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэлээ.

***2.1.2*** Хөвсгөл аймгийн хэмжээнд 2024 онд 22,316.6 сая төгрөгийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн санд бүрдүүлж 17,806.9 сая төгрөгийг зарцуулан 4,509.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн "Авто машины түр зогсоол барих, тохижилт /Түнэл сум, Байшинтын дөрөлж/" төсөл арга хэмжээний гүйцэтгэгч “Гранд Камел” ХХК нь зураг төсөв, ажлын даалгаварт заагдсан ажлаас 5.0 сая төгрөгийн явган хүний замын хашлаганы ажил дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг бүрэн авсан байна.
2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн "5 дугаар багт ухаалаг худаг нэмэгдүүлэх" төсөл арга хэмжээний гүйцэтгэгч “Хөвсгөл Цэнгэг Ус” ХХК нь зураг төсөвт заагдсан ажлаас 0.7 сая төгрөгийн худгийн барилгын тохижилтын ажил дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг бүрэн авсан байна.
3. Мөрөн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023-2024 онд хэрэгжсэн "Ухаалаг худаг орчмын тохижилт" төсөл арга хэмжээний гүйцэтгэгч “Өнө Гэрэгэ Констракшн” ХХК нь ажлын даалгаварт заагдсанаас 1.3 сая төгрөгийн худгийн тохижилтын ажил дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг бүрэн авсан байна.

Дээрх зөрчлүүд нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т "*Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна*", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,

[15] Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно

[16] Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ

тайлагнах журам"-ын 4.8.12-т "*Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно*" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна. Аудитаар тус зөрчлийг гүйцэтгэгч компаниар төлүүлэхээр **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэв.

4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн "5 дугаар багт ухаалаг худаг нэмэгдүүлэх" төсөл арга хэмжээний гүйцэтгэгч “Хөвсгөл Цэнгэг Ус” ХХК нь зураг төсөвт заагдсан ажлаас 3.5 сая төгрөгийн худгийн барилгын тохижилтын ажил дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг бүрэн авсан байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т "*Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна*", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12-т "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно*" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна. Аудитаар тус зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

*ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах ажлын хэсэг, улсын комисс, Барилга захиалагчийн хяналт төвийн холбогдох албан хаагчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжээгүй байхад ашиглалтад авч, санхүүжилтийг олгосон байна.*

## 2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 25 хувийг урсгал зардлын шинжтэй зүйлсэд зарцуулсан нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс иргэдийн хүртэх бодит үр өгөөжийг бууруулж байна.

***2.2.1*** Хөвсгөл аймгийн 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 31,069.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 696 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аас баталсан байна.

*Хүснэгт №11* */сая төгрөгөөр/*

| ОНХС | ИТХ-аар батлагдсан ТАХ | | Үүнээс: | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бүрэн хэрэгжсэн | | | Дутуу хэрэгжсэн | | | Огт хэрэгжээгүй | | |
| | тоо | Төсөвт өртөг | тоо | Дүн | Хувь | тоо | Дүн | Хувь | тоо | Дүн | Хувь |
| Аймгийн ОНХС | 629 | 15,034.4 | 480 | 10,391.2 | 76% | 24 | 894.4 | 4% | 125 | 3,332.0 | 20% |
| Сумын ОНХС | 67 | 16,035.5 | 54 | 5,425.8 | 81% | 8 | 37,762.9 | 12% | 5 | 3,677.2 | 7% |
| **НИЙТ** | **696** | **31,069.9** | **534** | **15,817.0** | **77%** | **32** | **38,657.3** | **5%** | **130** | **7,009.2** | **19%** |

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 77 хувь буюу 534 ТАХ тайлант онд бүрэн хэрэгжиж зорилтот үр дүнд хүрсэн бол 4 хувь буюу 32 ТАХ хэрэгжих шатандаа, 19 хувь буюу 130 ТАХ огт хэрэгжээгүй, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. Төсөл арга хэмжээнүүд нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварыг ОНХС-ийн эх үүсвэрээр бүрэн төвлөрүүлээгүй, ***Тухайлбал:*** Төмөрбулаг, Цэцэрлэг сумд нь малын тоо толгойн албан татварын орлого бүрдээгүйгээс өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой ТАХ-үүд нь хэрэгжээгүй байна.
- Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан
- Худалдан авах ажиллагааг төсвийн жилийн эхэнд зохион байгуулаагүйгээс гүйцэтгэгч тендерт оролцдоггүй эсвэл цаг агаарын нөхцөл байдлаас хамааран тайлант онд хэрэгжиж дуусдаггүй, ***Тухайлбал:*** Цагаан-Уул сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “ЗДТГ-ын засвар дээвэр халаалт гонхон” төсөл арга хэмжээ нь цаг агаар хүйтэрсний улмаас тайлант ондоо хэрэгжиж дуусаагүй байна.
- ТАХ-ний төсөвт өртгийг үндэслэлтэй тооцоолоогүйгээс худалдан авах ажиллагааг удаа дараа зарласан ч тендерт оролцогч оролцдоггүй, ***Тухайлбал:*** Цагааннуур сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 28.3 сая төгрөгийн төсөвт

өртөгтэй Цагааннуур сумын “Хуйтын гүүрний засвар” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 3 удаа зарласан боловч гүйцэтгэгч оролцоогүйн улмаас тайлант онд хэрэгжээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжиж эхэлсэн дараах төсөл арга хэмжээнүүд нь царцсан байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт № 12* */сая төгрөгөөр/*

| Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | Хэрэгжих хугацаа | Гэрээний дүн | 2024 онд олгосон санхүүжилт | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| Угтах үдэх хаалга орчмын тохижилт /Мөрөн сум/ | 270.3 | 2024-2025 | 225.7 | 96.2 | 129.5 |
| 6-р багийн ахмадын байр барих /Мөрөн сум/ | 402.0 | 2024-2025 | 401.0 | 90.1 | 310.9 |
| Сумын төвийн хогийн цэгийг дарж булшлах ажил /Тариалан сум/ | 784.8 | 2024-2026 | 774.0 | 200.0 | 574.0 |
| **НИЙТ** | **1,457.1** | | **1,400.7** | **386.3** | **1,014.4** |

Хүснэгтээс харахад 2025 онд үргэлжлэн хэрэгжих 3 төсөл арга хэмжээг шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтаас хасаж, санхүүжилтийн эх үүсвэрийг батлаагүй, цаашид эдгээр хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байгаагаас 1,457.1 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ зорилтот үр дүнд хүрээгүй, 386.3 сая төгрөгийн төсвийн хөрөнгө үр ашиггүй болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1[17], 27 дугаар зүйлийн 27.6.1[18] дэх заалттай тус тус нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

***2.2.2*** Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс 15,817.0 сая төгрөгийн 534 төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №13* */сая төгрөгөөр/*

| Аймаг, сумын нэр | Бүрэн хэрэгжсэн ТАХ | | Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүрсэн ТАХ | | хүрээгүй ТАХ | |
| | тоо | гэрээний дүн | тоо | дүн | тоо | дүн |
| Сумдын ОНХС | 480 | 10,391.2 | 479 | 10,372.2 | 1 | 19.0 |
| Аймгийн ОНХС | 54 | 5,425.8 | 52 | 5,173.2 | 2 | 252.6 |
| **нийт дүн** | **534** | **15,817.0** | **531** | **15,545.4** | **3** | **271.6** |

Хүснэгтээс харахад аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 5,173.2 сая төгрөгийн 52 төсөл арга хэмжээ, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 10,372.2 сая төгрөгийн 479 төсөл, арга хэмжээ нийт 15,545.4 сая төгрөгийн 531 төсөл, арга хэмжээ нь зорилтот үр дүнд хүрсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 252.6 сая төгрөгийн 2 ТАХ нь тайлант онд хэрэгжсэн боловч иргэдэд үр өгөөжөө өгч эхлээгүй байна. Үүнд:

- “Мөрөн сумын 5-р багт ухаалаг худаг гаргах” төсөл арга хэмжээнд 49.9 сая төгрөгийг зарцуулсан боловч цахилгааны эх үүсвэрийг шийдээгүй, усны холболтыг хийгээгүйгээс ашиглах боломжгүй,
- “Мөрөн сумын багуудад таксины зогсоол байгуулах” төсөл, арга хэмжээний гэрээг 202.8 сая төгрөгөөр байгуулж, 160.9 сая төгрөгийг зарцуулсан боловч төлөвлөсөн 3 цэгээс 2 цэгт таксины зогсоол байгуулж, байршил тодорхойгүйн улмаас 1 цэгт хийх зогсоолыг гүйцэтгээгүй байна.

Тус арга хэмжээнүүдэд ашиглалтад бүрэн шилжээгүй байгаа нь худгийн цахилгааны эх үүсвэр болон таксины зогсоолын байршлыг тодорхой тооцож төлөвлөөгүйтэй байна. Энэ нь

[17] төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;
[18] шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ;

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2[19] дах заалттай нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний 75 хувийг хөрөнгө оруулалтын шинжтэй үндсэн хөрөнгө болон бараа материалын зүйлсэд зарцуулсан бол 25 хувийг урсгал зардлын шинжтэй зүйлсэд зарцуулсан байна.

*Хүснэгт №14* *\/сая төгрөгөөр/*

| Хөрөнгийн бүртгэл | Аймгийн ОНХС | Сумын ОНХС | НИЙТ | Хувийн жин |
|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | 4,187.0 | 7,457.6 | 11,644.6 | 70% |
| Бараа материал | 65.1 | 686.9 | 752.0 | 5% |
| Урсгал зардал | 1,247.0 | 2,827.0 | 4,074.0 | 25% |
| **НИЙТ** | **5,499.1** | **10,971.5** | **16,470.6** | **100%** |

Нийт зардлын 25 хувийг урсгал зардлын шинжтэй зүйлсэд зарцуулсан байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөс иргэдийн хүртэх үр өгөөжийг бууруулж байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй зарим төсөл арга хэмжээнүүд нь иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зорилгоо хангахгүй, үр өгөөжийг тооцох боломжгүй байна. ***Тухайлбал:***

- Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлж буй ТАХ-үүдийн дийлэнх хувийг өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд жил бүр зарцуулдаг ба 2024 онд нийт 388.9 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлсэн,
- Малчдад зориулсан сургалт сурталчилгаа зохион байгуулахад 2024 онд 13 суманд 107.4 сая төгрөгийг урсгал зардлын шинжтэй зүйлд зарцуулсан,
- Хөдөөгийн багийн зам, даваа засварын ажлыг цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан жил бүр гүйцэтгэдэг,
- “Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах” төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 86.3 сая төгрөгийн тоолуурыг орон сууцны айл өрхүүдэд үнэ төлбөргүй суулгасан ба нийтийн эрх ашигт нийцээгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүндээ хүрч, иргэдийн амьдралд үр өгөөжөө өгч эхэлсэн **сайн жишээ**нээс дурдвал:

- ✓ Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 1,547.1 сая төгрөгийн гудамж талбайн гэрэлтүүлэг шинэчлэх, нэмэгдүүлэх төсөл арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Шаардлагатай цэгүүдэд хяналтын камерын тоог нэмэгдүүлж, шинэчлэх /Мөрөн сум/” төсөл арга хэмжээнд 299.7 сая төгрөгийг зарцуулж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлсэн байна.



- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Явган хүний гарцуудад гэрлэн дохио суурилуулах ажил /Дэлгэрмөрөн, Эрдмийн далай, Авьяас сургуулиудын явган хүний гарц/” төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр сургуулийн орчимд хүүхдүүд зам тээврийн хөдөлгөөнд оролцоход аюулгүй байдлыг хангах, Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Явган хүний лед гэрлэн гарц”-ыг сургууль, цэцэрлэг орчмын 10 цэгт байршуулснаар зам тээврийн осол буурах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болсон байна.
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Эрт илрүүлэг үзлэгт иргэдийг үе шаттайгаар хамруулах ажлын хүрээнд зүрхний зөөврийн эхо аппарат худалдан

[19] Хөрөнгө оруулалтын төслийн санал үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

авах” төсөл арга хэмжээнд 41.7 сая төгрөгийг зарцуулж, алсын дуудлагад ашиглаж байна.

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Мөрөн сумын үерийн далан нягтаршуулах, дагтаршуулах, сэргээх ажил эхлүүлэх” төсөл арга хэмжээнд 232.0 сая төгрөгийг зарцуулж, Мөрөн сумын 7,13-р багийн үерийн даланг сэргээж өндөр болгосноор 2024 онд тус багийн айл өрхүүд үерт өртөөгүй байна.




Аудитын хүрээнд 1590 иргэнээс авсан санал асуулгын дүнгээр *“Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд сэтгэл хангалуун байна уу?”* гэсэн асуултад иргэдийн 39 хувь нь тийм, 37 хувь нь дунд зэрэг, 14 хувь нь хангалтгүй, 10 хувь нь мэдэхгүй байна гэж үнэлсэн байна.

*Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 24 хувь нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжиж дуусаагүй, огт хэрэгжээгүй, нийт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 25 хувь нь урсгал зардлын шинжтэй зүйлсэд зарцуулсан, төлөвлөлтийг хууль журамд нийцүүлээгүйгээс 1,457.1 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ царцсан зэрэг нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс иргэдийн хүртэх бодит үр өгөөжийг бууруулж байна.*

### 2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,519.2 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.

***2.3.1.*** Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан 54 төсөл арга хэмжээнээс 50 төсөл арга хэмжээг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан 480 төсөл арга хэмжээнээс 475 төсөл арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ашиглалтын байдлыг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №15* *\/сая төгрөгөөр/*

| Аймаг, сумын нэр | Бүрэн хэрэгжсэн ТАХ | | Хөрөнгийн ашиглалт | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тоо | гэрээний дүн | Зориулалтын дагуу ашиглаж буй ТАХ | | Ашиглаагүй ТАХ | |
| | | | тоо | дүн | тоо | дүн |
| Сумын ОНХС | 480 | 10,391.2 | **475** | **9,535.2** | **5** | **856.1** |
| Аймгийн ОНХС | 54 | 5,425.8 | 50 | 5,064.2 | 4 | 361.6 |
| **Нийт дүн** | **534** | **15,817.0** | **525** | **14,599.4** | **9** | **1,217.6** |

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс 1,217.6 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №16* */сая төгрөгөөр/*

| № | Сумын нэр | Төсөл, арга хэмжээний нэр | Төсөв /сая.төг/ | Ашиглахгүй байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн ОНХС | Эхийн амрах байр барих ажлын үлдэгдэл /Баянзүрх сум/ | 142.5 | Цахилгаан, эрчим хүчний 380вт-д холбогдоогүй, эмнэлгийн хатуу эдлэл байхгүй. |
| 2 | Аймгийн ОНХС | Ухаалаг худаг гаргах /Мөрөн сум, 5-р баг/ | 49.9 | Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй |
| 3 | Аймгийн ОНХС | Дайвар бүтээгдэхүүн хагас болон бүрэн боловсруулах тоног төхөөрөмж/Цагаан-Уул/ | 124.8 | Тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж ашиглаж эхлээгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Аймгийн ОНХС | 5-р багийн иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийг барих /Мөрөн сум/ | 44.4 | Дараа онд Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр дотор заслын ажил хийгдэнэ. |
| 5 | Алаг-Эрдэнэ сум | Нэгдсэн халаалт | 399.6 | аймгийн ОНХС-аас 400.0 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн байсан боловч тус ажил хийгдээгүйгээс бүрэн ашиглах боломжгүй |
| 6 | Төмөрбулаг сум | Бүгсийн голд гүүр барих | 30.0 | Машин өгсөж, буух хэсэг хэт огцом байсныг гүйцэтгэгч ААН-ээр засуулахаар хандсан. |
| 7 | Улаан-Уул сум | Арьс шир элдэх, тоног төхөөрөмж | 20.0 | Ашиглах хүн байхгүй. |
| 8 | Цагаан-Уул сум | Арьс шир, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах | 317.6 | Тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж ашиглаж эхлээгүй. |
| 9 | Цэцэрлэг сум | Дизель генератор авах | 88.9 | Цэцэрлэгийн генераторыг суурилуулах байргүй. |
| **ДҮН** | | | **1,217.6** | |

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,217.6 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглахгүй, иргэдэд үр өгөөжөө өгөөгүй байгаа нь төлөвлөлтийн шатанд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөл, ашиглалтын дүгнэлтийг хангалтгүй гаргасантай холбоотой байна.

***2.3.2.*** Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “*Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам*”-ын 9.12-д өмчлөгч байгууллага хадгалалт, хамгаалалтыг хариуцахаар заасан.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн “Хогийн цэгийг дарж булшлах гинжит экскаватор худалдан авах /Мөрөн сум/” төсөл арга хэмжээний хүрээнд худалдан авсан гинжит экскаваторт чанарын баталгааны хугацаанд эвдрэл үүсэж, засвар үйлчилгээ шаардлагатай болсон байна. Уг асуудлаар бэлтгэн нийлүүлэгч компанид хандсан боловч тодорхой арга хэмжээг аваагүй байна.

Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хадгалалт, хамгаалалтын байдлыг хянаж үзэхэд дараах зөрчил илэрлээ.



146.4 сая төгрөгийн "Төв саадын тохижилт" төсөл арга хэмжээний лед гэрэл тасарч, шатсан байна.



75.2 сая төгрөгийн "13 дугаар багийн Шинээр тавигдсан засмал зам дагуу гэрэлтүүлгийн ажил" төсөл арга хэмжээний 2 гэрэлтүүлэг шатсан.



80.0 сая төгрөгийн "Төв саадын тохижилт" төсөл арга хэмжээний /2023 онд гүйцэтгэсэн/ хүрээнд хийгдсэн усан оргилуур нь огт ажиллаагүй байна.

Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон 301.6 сая төгрөгийн барилга байгууламжийн чанар байдал хангалтгүй байгаа нь өмчлөгч байгууллагын хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгааг харуулж байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах ажлыг зохион байгуулж ажиллахыг Мөрөн сумын Засаг даргад **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

*Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 1,217.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй, 301.6 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан, нийт 1,519.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нь орон нутгийн хөгжил болон иргэдийг тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болоогүй, ашиглаж эхлээгүй байна.*

| БҮЛЭГ 3: | **Захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ чанаргүй болох, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг үүсгэж байна.** |
|---|---|

### 3.1. Захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ чанаргүй болох, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг үүсгэж байна.

***3.1.1.*** Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “*Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам*”-д Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тухайн шатны ИТХ хяналт хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо болон аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж, холбогдох газруудад зөвлөмж, чиглэлийг хүргүүлж ажилласан байна.

Сумдын ИТХ болон сумын Засаг даргын дэргэдэх дотоод хяналтын нэгжээс 2024 оны сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байдлыг графикаар харуулбал:

*График №5*




Дараах 6 сумын ИТХ нь хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Арбулаг сумын ИТХ
- Бүрэнтогтох сумын ИТХ
- Галт сумын ИТХ
- Цэцэрлэг сумын ИТХ
- Цагаан-Үүр сумын ИТХ
- Чандмань-Өндөр сумын ИТХ

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2[20] дахь заалттай нийцэхгүй байна.

Мөрөн сумын ИТХ-аас орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоотой хяналт үнэлгээ хийх журмыг 2023 онд баталж 2024 оноос хэрэгжүүлсэн байна. Тус журамд нь төсөл арга хэмжээний шат бүрд хяналтыг хэрэгжүүлж, нэгтгэн дүгнэж холбогдох арга хэмжээг авч

[20] Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

ажиллах талаар тусгасан байна. Журмыг хэрэгжүүлж ажилласнаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний явц, гүйцэтгэлд сумын ИТХ болон иргэд, хөндлөнгийн байгууллагын хяналт сайжрах сайн талтай байна.

***3.1.2*** Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2, 2.8-д заасны дагуу аймгийн Засаг дарга болон сумдын Засаг дарга нар “Барилга захиалагчийн хяналтын төв”-тэй гэрээ байгуулан захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагаас барилга угсралтын ажлын явцад үе шатны хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, зураг, төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй байна. ***Тухайлбал:*** Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Авто машины түр зогсоол барих, тохижилт /Түнэл сум, Байшинтын дөрөлж/", "5 дугаар багт ухаалаг худаг нэмэгдүүлэх" зэрэг ажлуудад хийсэн хяналт хангалтгүйгээс зураг, төсөвт заагдсан ажлыг хийгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан.

“Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үе шатны хяналтыг хийдэггүй, дүгнэлтийг ерөнхий байдлаар өгдөг, хурлын тэмдэглэлд ажлын явц, гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй тусгадаггүй, аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар баталж, Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 4/3.18 дахь “*Захиалагч барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих замаар хувийн, нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална*”, 4/3.10 дахь ”*Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

“Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ийн хяналтыг сайжруулах талаар өмнөх аудитуудаар албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчил жил бүр давтагдаж байгаа тул аймгийн Засаг даргын эрх хэмжээний хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

***3.1.3*** Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд буюу 2024 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт 75 хувьтай байна.

*Хүснэгт № 17* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар | | Хэрэгжилт | | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Төлбөрийн акт | 2 | 26.0 | 2 | 26.0 | 100 |
| Албан шаардлага | 10 | 7,838.6 | 9 | 5,174.2 | 66 |
| Зөвлөмж | 12 | 2,940.2 | 12 | 2,940.2 | 100 |
| **НИЙТ** | **24** | **10,804.8** | **23** | **8,140.4** | **86** |

Өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ийн төлөвлөлтийг хууль, журамд нийцүүлж гүйцэтгэх талаар аймгийн Засаг даргад өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, зөрчил жил бүр давтагдсаар байна.

*ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Барилга захиалагчийн хяналтын төв”-өөс хийсэн гүйцэтгэлийн хяналт хангалтгүй байгаа нь тухайн төсөл, арга хэмжээ чанаргүй болох, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсгэж байна.*

### 3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 818.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

***3.2.1.*** Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталса***н*** “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2, 9.9-т заасны дагуу 24 сумын ЗДТГ-аас ОНХС-ийн 2024 оны гүйцэтгэл, зарцуулалтын тайланг аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлж нэгтгүүлсэн байна. Мөн журмын 9.11-т заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнажээ.

***3.2.2.*** Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд 4,187.0 сая төгрөгийн хөрөнгө, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд 10,715.6 сая төгрөгийн хөрөнгө, нийт 17,806.9 сая төгрөгийн хөрөнгө бий болсныг ашиглагч байгууллагад шилжүүлж нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

Аудитын хугацаанд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 818.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

***3.2.3*** ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем нь ОНХС-аас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийн санг бүрдүүлэх зорилготой бөгөөд тус төсөл, арга хэмжээ хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих боломжийг бүрдүүлэх, цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийхэд ашиглах зорилготой хэрэгжиж эхэлсэн систем юм.

Аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг аймаг, сумдын ЗДТГ нь удирдлагын мэдээллийн системд оруулах чиг үүрэгтэй.

Удирдлагын мэдээллийн системд Хөвсгөл аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 31,069.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 696 төсөл арга хэмжээнээс 29,644.6 сая төгрөгийн 615 төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулсан байна.

Сумын ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд зарим сумд дутуу мэдээлсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №19* */сая төгрөгөөр/*

| № | Аймаг, сумын нэр | ИТХ-аар баталсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний | | Үүнээс: ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бүрэн оруулсан ТАХ-ний | | Дутуу оруулсан ТАХ-ний | | Огт оруулаагүй ТАХ-ний | |
| | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн |
| **1** | Баянзүрх | 35 | 489.9 | 16 | 250.9 | 19 | 239.0 | | |
| **2** | Бүрэнтогтох | 48 | 1,086.1 | 37 | 909.1 | | | 11 | 177.1 |
| **3** | Тосонцэнгэл | 31 | 444.9 | 25 | 366.7 | | | 6 | 78.3 |
| **4** | Түнэл | 25 | 494.6 | 11 | 285.9 | 1 | 9.0 | 13 | 199.7 |
| **5** | Ханх | 30 | 430.2 | 9 | 73.0 | | | 21 | 357.2 |
| **6** | Цэцэрлэг | 40 | 2,211.3 | 30 | 1,846.2 | | | 10 | 365.0 |
| | **Сумын дүн** | **238** | **6,034.9** | **157** | **4,609.7** | **20** | **248** | **61** | **1,177.3** |

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд Баянзүрх, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Түнэл, Ханх, Цэцэрлэг сумд дутуу мэдээлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10

дугаар зүйлийн 10.2[21] дахь заалттай нийцэхгүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

*График №6*




Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгад хамрагдсан 1590 иргэний 37 хувь нь УМС-ээс мэдээлэл авдаггүй гэж хариулсан бол 15 хувь нь ОНХС-ийн төлөвлөлттэй холбоотой, 32 хувь нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой, 16 хувь нь худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг тус тус авдаг гэж хариулсан байна.

***3.2.4*** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2, 6 дугаар зүйлийн 6.1.1, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 11 дүгээр хавсралтын хүрээнд www.shilendans.gov.mn цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор тогтмол мэдээлэхээр заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийг Шилэн дансны цахим хуудсанд ТЕЗ болон 23 сум, 1 тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч олон нийтэд ил, тод үнэн зөв мэдээлсэн байна.

*ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, бусад холбогдох тайланг журмын дагуу тайлагнаж ажилласан хэдий ч зарим сумд удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг дутуу мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээллийг авч чадахгүй байх нөхцөл үүсэж байна.*

*Аудитаар нийт 15,864.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 6.9 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 11,463.1 сая төгрөгийн зөрчилд 15 албан шаардлага, 4,394.0 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.*

[21] ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Хөвсгөл аймагт олгохоор баталсан дүнг 748.6 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй тооцоолоогүйгээс 528.4 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн, өмнөх жилийн малын тоо толгойн албан татварын давсан орлого 29.1 сая төгрөгийг тайлант онд эх үүсвэр болгоогүй, нийт 1,306.1 сая төгрөгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан нь орон нутаг нөөц боломжоо бүрэн дайчилж ажиллахгүй байгааг харуулж байна.
2. Шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж, өмнөх онд хэрэгжиж эхэлсэн төсөл арга хэмжээг үндэслэлгүйгээр хасаж байгаа нь шат шатны иргэдийн хурлын төлөөлөгчид нь холбогдох хууль журмыг хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах ажлын хэсэг, улсын комисс, Барилга захиалагчийн хяналт төвийн холбогдох албан хаагчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжээгүй байхад ашиглалтад авч, санхүүжилтийг олгосон нь төрийн албан хаагчдын хариуцлагүй байдлыг илтгэж байна.
4. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 24 хувь нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжиж дуусаагүй, огт хэрэгжээгүй, нийт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 25 хувь нь урсгал зардлын шинжтэй зүйлсэд зарцуулсан, төлөвлөлтийг хууль журамд нийцүүлээгүйгээс 1,457.1 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ царцсан зэрэг нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс иргэдийн хүртэх бодит үр өгөөжийг бууруулж байна.
5. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 1,217.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй, 301.6 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан, нийт 1,519.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нь орон нутгийн хөгжил болон иргэдийг тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болоогүй, ашиглаж эхлээгүй байна.
